

**БАРИЛГА БАЙГУУЛАМЖИЙГ АШИГЛАЛТАД
ОРУУЛАХ КОМИССЫН ДҮГНЭЛТ**

2025 оны 04 сарын 23-ны өдөр

Дугаар БА-115/2025 Улаанбаатар хот

Нэг. Удиртгал хэсэг

Монгол Улсын нийслэлийн Хан Уул дүүргийн 23-р дугаар хороонд баригдсан бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 (тав) автомашины дулаан зогсоолтой, 2 давхар, аялал жуулалын салбарын мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга байгууламжид Засгийн газрын 2021 оны 212 дугаар тогтоол, нийслэлийн Засаг даргын 2024 оны 05 дугаар сарын 03-ны өдрийн А/503 дугаар захирамжийн шийдвэрээр байгуулагдсан 15 хүний бүрэлдэхүүнтэй барилга байгууламжийг ашиглалтад оруулах комисс 2025 оны 01 сарын 22-ны өдрөөс эхлэн 1 хоногийн хугацаанд ажиллан тухайн барилга байгууламж, түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийв.

Хоёр. Ерөнхий мэдээлэл


- 2.1 Барилгын ажлын зөвшөөрлийн гэрчилгээний 2022.08.05 огноо, 603/2022 дугаар, 2023.08.16 огноо, 603/2022 дугаар
- 2.2 Барилга байгууламжийн зураг төслийн шифр дугаар ЭЭП-04/21
- 2.3 Захиалагч: Монгол улсын соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж, 265637 холбоо барих утас
- 2.4 Барилгын ажлын гүйцэтгэгч: "Жон У Женерал Констракшн" ХХК оноосон нэр, 9019097678 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 6544401 регистрийн дугаар, БУ12-346/20 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 16-р хороо, 16 хороолол, 645-905 тоот, 80442757, 99713336 холбоо барих утас,
- 2.5 Барилгын ажлын Туслан гүйцэтгэгч: Унага Трейд ХХК оноосон нэр, 0311001042 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 2006626 регистрийн дугаар, БУ44-954/22 барилгын ажил гүйцэтгэх тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Баянхонгор, Баянхонгор, 1- баг, Номгон, 0, 99442050 холбоо барих утас
- 2.6 Барилга байгууламжийн зураг төсөл зохиогч байгууллага: ЭН ЭЙ ПИ групп ХХК оноосон нэр, 9011105099 Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар, 5146933 регистрийн дугаар, ЗТ16-735/22 зураг төсөл боловсруулах тусгай зөвшөөрлийн дугаар, Хаяг: Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 6-р хороо, бага тойруу, Метро биенес төв 11 давхар 1106, 1107 тоот 311802, 99180215 холбоо барих утас
- 2.7 Барилга байгууламжийн ашиглагч, өмчлөгч байгууллага: Монгол улсын соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яам, Сүхбаатар дүүрэг, 7-р хороо, Денверийн гудамж, 265637 холбоо барих утас

2.8 Барилга байгууламжийн төлөв байдал: **Шаардлага хангасан.**

Гурав. Дүгнэлтийн хэсэг

✓ Барилга байгууламжийг ашиглалтад оруулах:

- Барилгын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1-д заасан шаардлагыг хангасан барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан тул



Энэ бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 (тав) автомашины дулаан зогсоолтой, 2 давхар, аялал жуулалын салбарын мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга байгууламж түүний холбогдох баримт бичигт үзлэг шалгалт хийж, барилгын ажлын гүйцэтгэл, чанарт үнэлгээ, дүгнэлт өгсний үндсэн дээр комиссоос ДҮГНЭСЭН нь:

Энэ барилга байгууламжийн барилгын ажил зохих зөвшөөрөл, зураг төслийн дагуу бүрэн хийгдэж, хууль тогтоомжид заасан шаардлагыг хангасан гэж үзээд ашиглалтад оруулах нь зүйтэй гэж дүгнэв.

3.1. Барилга байгууламжийг ашиглалтад оруулах болсонтой холбогдуулан захиалагч, гүйцэтгэгч, зураг төсөл зохиогч байгууллагуудад даалгах нь:

- а) барилга байгууламжийн иж бүрэн баримт бичгийн эх хувийг архивт, үлдэх хувийг ашиглагч буюу өмчлөгч, эзэмшигч байгууллагад ... хоногийн дотор багтаан шилжүүлэх;
- б) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацаанд ашиглалтын хэвийн нөхцөлийг хангах болон уг хугацаа дуусгавар болохтой холбоотой хууль тогтоомжид заасан үйл ажиллагааг хэрэгжүүлэх.

3.2. Ашиглагч байгууллагад:

- а) барилга байгууламжийг ашиглалтад зүгшрүүлэх, тохируулах хугацааг дуусгавар болгоход оролцох;
- б) барилга байгууламжийн хувийн хэргийг хөтөлж эхлүүлэх;
- в) барилга байгууламжийн хэвийн ашиглалттай холбоотой хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг үүгээр даалгаж байна.

3.3. Комиссын акт 3 хуудас, хуралдааны тэмдэглэл 5 хуудас, комиссоос өгсөн үүрэг даалгаврын биелэлтийн жагсаалт 30 хуудас материал болон барилга байгууламжийн бичиг баримтын жагсаалт болох хуудас материалыг дүгнэлтэд хавсаргаж байна.

Дөрөв. Дүгнэлтийн баталгаажуулалт

4.1 Бага төвөгшилтэй ангиллын зоорьтой 5 (тав) автомашины дулаан зогсоолтой, 2 давхар, аялал жуулчлалын салбарын мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга байгууламжийг ашиглалтад оруулах дүгнэлт гаргасан:

Хан-Уул дүүргийн 23 дугаар хороо,
Соёл, спорт, аялал жуулчлал, залуучуудын яамны захиалгатай,
зоорьтой 5 (тав) автомашины дулаан зогсоолтой, 2 давхар,
аялал жуулчлалын салбарын мэргэжил сургалт, үйлдвэрлэлийн төвийн барилга

Комиссын дарга: Хяналт шалгалтын
газрын Барилга байгууламжийн ашиглалт,
бүртгэлийн хэлтсийн даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч



(А.Мөнгөн)

Нарийн бичгийн дарга:
Соёл, спорт, аялал жуулчлал,
залуучуудын яамны Санхүү, хөрөнгө
оруулалтын газрын хөрөнгө оруулалтын
хэлтсийн дарга



(Х.Дэлгэрмаа)

Барилга байгууламжийг ашиглалтад оруулах комиссын үүрэг даалгаврын
биелэлтийн хуудасны хамт хүчинтэй.

